





Ж -2-EP-12-01

ЦУСНЫ ДОНОРЫГ АЛДАРШУУЛАХ, УРАМШУУЛАХ ЖУРАМ

ЭХ ХУВЬ 1



Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Захиргаа, маркетингийн алба				
Баримт бичгийн дугаар:Ж-2-EP-12-01		Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам		
Хувилбар №01	Хэрэгжиж эхэлсэн огноо: 2020.02.20	Өөрчлөлт	Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо:	Хуудас 1/ 9 нийт хуудасны тоо

Нийгмийн ажилтан	ЧЦССА-ны дарга	ЦССҮТ –ийн захирал
Д.Дулмаа	Т.Алимаа	Н.Эрдэнэбаяр
Боловсруулсан:	Хянасан:	Баталсан:
Огноо: 2020.01.10	Огноо: 2020.02.20	Огноо:
Гарын үсэг 	Гарын үсэг 	Гарын үсэг 



Өөрчлөлт хийгдээгүй	Албан тушаал	Гарын үсэг
Зөвшөөрсөн	ЗМЯ НЗМЯ	
Хянасан	УИХБА гарга	
Хүчинтэй хугацаа	20 29 он 02 сар 20 өдөр	

Өөрчлөлт хийгдээгүй	Албан тушаал	Гарын үсэг
Зөвшөөрсөн	ЗМАНОГ дарга	
Хянасан	2024.08.20 УЧАБА гарга	
Хүчинтэй хугацаа	20 25 он 08 сар 20 өдөр	

Өөрчлөлт хийгдээгүй	Албан тушаал	Гарын үсэг
Зөвшөөрсөн	УЧАБА -ны дарга	
Хянасан	ЗМАНОГ дарга	
Хүчинтэй хугацаа	20 26 он 08 сар 20 өдөр	

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Захиргаа, маркетингийн алба				
Баримт бичгийн дугаар: Ж-2-ЕР-12-01		Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам		
Хувилбар №01	Хэрэгжиж эхэлсэн огноо: 2020.02.20	Өөрчлөлт	Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо:	Хуудас 2/9 нийт хуудасны тоо

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

Д.д	Хуудас №	Бүлэг №	Өөрчлөлт оруулсан огноо	Оруулсан өөрчлөлтийн утга	Шалтгаан	ЧАД-н гарын үсэг	Даргын гарын үсэг
1	2/9	9	2020.02.20	Заалтууд нэмсэн, өөрчлөгдсөн			
2							

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Захиргаа, маркетингийн алба				
Баримт бичгийн дугаар:Ж-2-ЕР-12-01		Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам		
Хувилбар №01	Хэрэгжиж эхэлсэн огноо: 2020.02.20	Өөрчлөлт	Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо:	Хуудас 3/ 9 нийт хуудасны тоо

Агуулга

Д/д	Бүлэг	Хуудас
	Өөрчлөлт оруулсан бүртгэл	
1.	Тодорхойлолт, товчилсон үг	5
2.	Зорилго	
3.	Хамрах хүрээ	
4.	Журмаар зохицуулах үйл ажиллагаа	
4.1.	Шагналын төрөл	5
4.2.	Урамшууллын төрөл	6
4.3.	Шагнал олгох болзол, шаардлага	6-7
4.4.	Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох	7
4.5.	Урамшуулал олгох болзол	7-8
4.6.	Бусад	8
4.7.	Санхүүжилт	8
5.	Лавлах материал	
6.	Хавсралт	9
	7. Холбогдох бичиг баримт	

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Захиргаа, маркетингийн алба		Баримт бичгийн дугаар:Ж-2-ЕР-12-01		
Хувилбар №01		Хэрэгжиж эхэлсэн огноо: 2020.02.20	Өөрчлөлт	Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо:
				Хуудас 4/ 9 нийт хуудасны тоо

1. Тодорхойлолт, товчилсон үг

1.1.Тодорхойлолт

1.1.1. “Донорын бүртгэл мэдээллийн сан” / цаашид ДБМС гэх/ гэж цусны донорын талаарх мэдээлэл агуулсан цахим болон цаасан бүртгэлийн санг;

1.1.2. “Цусны донорын эрүүл мэндийн карт” /цаашид ДЭМК гэх/ гэж донорын иргэний болон эрүүл мэндийн асуумж, үзлэг, цусаа өгсөн тухай мэдээлэл агуулсан баримт бичгийг;

1.1.3. “Донор алдаршуулах, урамшуулах” гэж тогтмол хугацаанд цусаа бэлэглэсэн донорыг олон нийтэд таниулах, донор хадгалалтыг сайжруулах, сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх зорилгоор, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнийг Цусны албаны шагналаар шагнаж урамшуулахыг.

1.2. Товчилсон үг:

1.2.1. ЦА –Цусны алба

1.2.2. ЦССҮТ- Цус сэлбэлт судлалын үндэсний төв

1.2.3. ЦДБМС –Цусны донорын бүртгэл мэдээллийн сан

1.2.4. ЦДЭМК –Цусны донорын эрүүл мэндийн карт

2. Зорилго

2.1. Донорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг үндэслэн сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх, цус,цусны бүрэлдэхүүн хэсгээ тогтмол хугацаанд бэлэглэж байгаа доноруудын үйлсийг сурталчлан, донор хадгалалтыг сайжруулах, сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнийг Цусны албаны шагналаар алдаршуулж урамшуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

3. Хамрах хүрээ

3.1. Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх, цус,цусны бүрэлдэхүүн хэсгээ тогтмол хугацаанд бэлэглэж байгаа доноруудын үйлсийг сурталчлах, алдаршуулах, урамшуулах, донор хадгалалтыг сайжруулах, сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх үйлсэд идэвхитэй оролцсон төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн, цусны донорт энэ журам хамаарна.

4. Журмаар зохицуулах үйл ажиллагаа

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Захиргаа, маркетингийн алба				
Баримт бичгийн дугаар:Ж-2-ЕР-12-01		Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам		
Хувилбар №01	Хэрэгжиж эхэлсэн огноо: 2020.02.20	Өөрчлөлт	Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо:	Хуудас 5/ 9 нийт хуудасны тоо

4.1. Донор алдаршуулах үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээг ашиглан хэрэгжүүлнэ.

4.2. Онцгой амжилт гаргасан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн, цусны донор, ЦССҮТ-ийн ажилтныг алдаршуулахтай холбоотой зардлыг Цусны алба хариуцаж болно.

4.3. Алдаршуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нийгмийн ажилтан, олон нийттэй харилцах менежер, хэвлэл мэдээллийн ажилтнууд хариуцан гүйцэтгэнэ.

4.4. Цусны донорыг алдаршуулах зорилгоор дараах онцлох тэмдэг олгож болно:

4.4.1. "Бахархал-50" онцлох тэмдэг, үнэмлэх;

4.4.2. "Бахархал-40" онцлох тэмдэг, үнэмлэх;

4.4.3. "Бахархал-30" онцлох тэмдэг, үнэмлэх;

4.4.4. "Бахархал-20" онцлох тэмдэг, үнэмлэх;

4.4.5. "Бахархал-10" онцлох тэмдэг, үнэмлэх;

4.4.6. "Цусны донор" онцлох тэмдэг, үнэмлэх.

4.5. Цусны донорыг алдаршуулах онцлох тэмдгийг дараах болзол хангасан цусны донорт олгоно:

4.5.1. "Бахархал-50" онцлох тэмдэгээр:

- 50 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн.

4.5.2. "Бахархал-40" онцлох тэмдэгээр:

- 40 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн.

4.5.3. "Бахархал-30" онцлох тэмдэгээр:

- 30 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн.

4.5.4. "Бахархал-20" онцлох тэмдэгээр:

- 20 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн.

4.5.5. "Бахархал-10" онцлох тэмдэгээр:

- 10 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн.

4.5.6. "Цусны албаны талархалын бичиг"-ээр:

- 5 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн.

4.5.7. "Цусны донор" онцлох тэмдэгээр:

- 2 болон түүнээс дээш удаа бэлэглэсэн.

4.6. Цусны донорыг алдаршуулах онцлох тэмдэг олгох болзол хангасан цусны донорын судалгааг донор зохион байгуулалтын асуудал эрхэлсэн нэгж гарган ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын шийдвэрээр олгоно.

4.7. Цусны донорыг урамшуулах зорилгоор дараах шагналыг олгож болно.

4.8. Шагналын төрөл:

4.8.1. Цусны албаны шагнал нь дараах төрөлтэй байна:

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Захиргаа, маркетингийн алба		Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам		
Баримт бичгийн дугаар:Ж-2-ЕР-12-01				
Хувилбар №01	Хэрэгжиж эхэлсэн огноо: 2020.02.20	Өөрчлөлт	Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо:	Хуудас 6/ 9 нийт хуудасны тоо

а/ Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд:

- “Цусны албаны Хүндэт тэмдэг”;
- “Цусны албаны Хүндэт өргөмжлөл”;
- “Цусны албаны Талархалын бичиг”.

б/ Хүндэт донор:

- “Цусны албаны Хүндэт тэмдэг”, үнэмлэх, 100,000 төгрөг
- “Онцлох донор” медаль, үнэмлэх, 80.000 төгрөг, “Алтан донор” медаль, үнэмлэх, 50.000 төгрөг, “Мөнгөн донор” медаль, үнэмлэх, 30.000 төгрөг, “Хүрэл донор” медаль, үнэмлэх, 20.000 төгрөг;
- “Цусны албаны Талархалын бичиг”.

4.9. Цусны албаны шагналыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын шийдвэрээр олгоно.

4.10. Шагнал олгох болзол, шаардлага:

4.10.1. Донор хадгалалтыг сайжруулах, сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх чиглэлээр олон жил үр бүтээлтэй ажилласан, Цусны албаны үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан, хүмүүнлэгийн үйлсийг дэлгэрүүлэхэд идэвхи санаачлагатай ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан, Хүндэт донорыг “Цусны албаны Хүндэт тэмдэг”-ээр;

4.10.2. Донор хадгалалтыг сайжруулах, сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх чиглэлээр олон жил үр бүтээлтэй ажилласан, хүмүүнлэгийн үйлсийг сурталчлан дэлгэрүүлэхэд манлайлан оролцож Цусны албаны үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулсан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олныг “Цусны албаны Хүндэт өргөмжлөл”-өөр;

4.10.3. Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх, байнгын донорын тоог нэмэгдүүлэх донорын үйлсийг сурталчлах үйлсэд хувь нэмэр оруулсан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан, донорыг “Цусны албаны талархалын бичиг”-ээр;

4.10.4. Цусны донорын цус өгөлтийн удаагаар тооцож дараах шагналаар шагнана:

а/ “Онцлох донор” медалиар:

- 200 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн цусны донор;
- 130 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн ховор бүлгийн

/резус сөрөг/ донорыг;

б/ “Алтан донор” медалиар:

- 150 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн цусны донор;

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Захиргаа, маркетингийн алба				
Баримт бичгийн дугаар: Ж-2-ЕР-12-01		Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам		
Хувилбар №01	Хэрэгжиж эхэлсэн огноо: 2020.02.20	Өөрчлөлт	Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо:	Хуудас 7/9 нийт хуудасны тоо

• 90 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн ховор бүлгийн /резус сөрөг/ донорыг;

в/ "Мөнгөн донор" медалиар:

• 100-аас дээш удаа цусаа бэлэглэсэн цусны донор;
• 70 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн ховор бүлгийн /резус сөрөг/ донорыг.

г/ "Хүрэл донор" медалиар:

• 70-аас дээш удаа цусаа бэлэглэсэн цусны донор;
• 50 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн ховор бүлгийн /резус сөрөг/ донорыг.

4.11. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4.11.1. Энэ журмын 4.10 дахь хэсэгт заасан болзол, шаардлагыг хангасан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, донорыг нийгмийн ажилтан болон төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нэр дэвшүүлнэ.

4.11.2. Цусны донорын цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн талаарх мэдээллийг ЦДБМС, ЦДЭМК-аас ЦССҮТ-ын донор зохион байгуулалтын асуудал эрхэлсэн нэгж шалган үзэж, Төвийн Ерөнхий захиралд танилцуулна.

4.11.3. Болзол, шаардлага хангасан төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан, донорыг Төвийн захирлын шийдвэрээр шагнаж, урамшуулна.

4.12. Урамшууллын төрөл

4.12.1. Цусны донорын урамшуулал нь дараах төрөлтэй байна:

а/ үнэ бүхий зүйл;

б/ эрхийн болон хөнгөлөлтийн бичиг;

4.13. Урамшуулал олгох болзол

4.13.1. Тухайн жилд авлагагүйгээр цусаа бэлэглэсэн удааг оноогоор үнэлэн цусны донорт үнэ бүхий зүйл олгож болно.

4.13.2. Цусны донорын цус өгөлтийн удааг дараах зарчмаар оноогоор үнэлж, урамшуулал олгоно:

а/ Цусны сийвэнгийн 1 удаагийн өгөлт-1 оноо;

б/ Бүхэл цусны 1 удаагийн өгөлт-2 оноо /эрэгтэй/;

в/ Бүхэл цусны 1 удаагийн өгөлт-3 оноо /эмэгтэй/;

г/ Улаан эс, ялтаст эсийн 1 удаагийн өгөлт- 4 оноо;

д/ Сөрөг бүлгийн донорын сийвэн өгөлт- 3 оноо;

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Захиргаа, маркетингийн алба				
Баримт бичгийн дугаар:Ж-2-ЕР-12-01		Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам		
Хувилбар №01	Хэрэгжиж эхэлсэн огноо: 2020.02.20	Өөрчлөлт	Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо:	Хуудас 8/ 9 нийт хуудасны тоо

е/ Сөрөг бүлгийн донорын бүхэл цусны 1 удаагийн өгөлт- 4 оноо;
ж/ Сөрөг бүлгийн донорын улаан эс, ялтаст эсийн 1 удаагийн өгөлт- 6 оноо.

4.13.3. Цусны донорын цус өгөлтийн удааг энэ журмын 4.13.2-т заасан оноогоор үржүүлж урамшууллын нийт оноог гаргана.

4.13.4. ЦССҮТ-ийн донор зохион байгуулалтын асуудал эрхэлсэн нэгж энэхүү журмын хавсралтад заасан онооны урамшууллын тодорхойлолтын хуудас /хавсралт/ -ыг цусны донорт олгож, онооны урамшууллын бүртгэлд цусны донор болон эмч гарын үсэг зурж баталгаажилт хийнэ.

4.13.5. Энэ журмын 7.3-т заасан нийт оноог харгалзан урамшуулал олгох цусны доноруудын жагсаалтыг ЦССҮТ-ийн донор зохион байгуулалтын асуудал эрхэлсэн нэгж гаргана.

4.13.6. Цусны донорын цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн талаарх мэдээллийг ДБМС, ДЭМК-аас нийгмийн ажилтан шалган үзэж, Төвийн Ерөнхий захиралд танилцуулна.

4.13.7. Урамшууллын төрөл, хэмжээг ЦССҮТ-ийн Удирдлагын зөвлөлөөр оны эцэст шийдвэрлэж, дараа оны эхний сард цусны донорт гардуулна.

4.13.8. Урамшуулал олгох үйл ажиллагааг Донор зохион байгуулалтын тасаг зохион байгуулна.

4.14. Шагнал, урамшууллын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг нийгмийн ажилтан хариуцан ажиллах бөгөөд тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж Төвийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулна.

4.15. Донор алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг нийгмийн ажилтан, олон нийттэй харилцах менежер, хэвлэл мэдээллийн ажилтнууд хариуцан гүйцэтгэнэ.

4.16. Урамшууллыг 1 жилийн хугацаанд олгох бөгөөд нөхөн олгохгүй.

4.17. Цусны донорын урамшууллын эд зүйл олгох үйл ажиллагааг ЦССҮТ-ийн нярав хариуцан гүйцэтгэж, ахлах нягтлан бодогч, хуулийн зөвлөх нар хяналт тавина.

4.18. Донор алдаршуулах, урамшуулахтай холбоотой санхүүжилтийг Донорын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

5. Лавлах материал

1. Донорын тухай хууль
2. Эрүүл мэндийн тухай хууль
3. Төсвийн тухай хууль

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Захиргаа, маркетингийн алба				
Баримт бичгийн дугаар:Ж-2-ЕР-12-01		Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам		
Хувилбар №01	Хэрэгжиж эхэлсэн огноо: 2020.02.20	Өөрчлөлт	Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо:	Хуудас 9/9 нийт хуудасны тоо

6.Хавсралт
М-ДМ-4-16-01

ОНООНЫ УРАМШУУЛЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

..... бүлгийн резус бүлгийн цусны донор
регистрийн дугаартай овгийн
..... -ний нь 20..... онд
..... удаагийн бүхэл цус, удаагийн сийвэн, удаагийн улаан
эс, ялтаст эс өгч, нийт оноо цуглуулсан тул оноонд тохирох
урамшууллыг сонголтоор олгуулахаар тодорхойлов.

Их эмч...../гарын үсэг/

Цусны донор /гарын үсэг/

.....оны.....сарын.....өдөр

М-ДМ-4-16-01

ОНООНЫ УРАМШУУЛАЛД ӨГСӨН ЭД ЗҮЙЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

..... бүлгийн резус бүлгийн цусны донор
регистрийн дугаартай овгийн
..... -ний нь 20..... онд нийт
..... оноо цуглуулсан тул оноонд тохирох дараах урамшууллыг сонгон
авав:

.....
..

/урамшууллын эд зүйлийн нэр/

Урамшуулал олгосон: Нярав...../гарын үсэг/

Хүлээн авсан: Цусны донор /гарын үсэг/

.....оны.....сарын.....өдөр

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Захиргаа, маркетингийн алба				
Баримт бичгийн дугаар:Ж-2-ЕР-12-01		Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам		
Хувилбар №01	Хэрэгжиж эхэлсэн огноо: 2020.02.20	Өөрчлөлт	Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо:	Хуудас 10/ 9 нийт хуудасны тоо